

ИФЛА - ЮНЕСКО

Нийтийн Номын Сангийн Тунхаглал

2022



Нийтийн номын сан дараах нөхцөлийг бий болгодог:

- ардчилсан нийгмийг хөгжүүлэх
- иргэдийг идэвхжүүлэх
- Хувь хүн болон нийгмийн бүлгүүд насан туршдаа суралцах, бие даасан шийдвэр гаргах, соёлыг хөгжүүлэх

Нийтийн номын сан бол:

- орон нутгийн мэдээллийн төв
- хамтын нөхөрлөлийг бүтээгч

Нийтийн номын сан бүх иргэдэд санал болгодог:

- сан хөмрөг болон үйлчилгээнд үнэ төлбөргүй, эрх тэгш хандах
- мэдээллийн бүх төрөлд чөлөөтэй хандах
- номын сангийн бүртгэлтэй үйлчилгээ, түүний дотор алсаас хандах үйлчилгээ

Тусгай хэрэгцээт хүмүүст зориулж:

- тусгай үйлчилгээ болон баримтууд санал болгодог

Дараах зүйлд дэмжлэг үзүүлдэг байх ёстой:

- албан болон албан бус боловсрол
- унших, медиа ашиглах, мэдээллийн болон цахим боловсрол
- хувь хүний хөгжил, бүтээлч байдал, соёлын олон янз байдал
- мэдлэг бүтээх, хуваалцах
- шинжлэх ухааны мэдлэг мэдээлэлд нээлттэй хандах
- соёлын өвийг хадгалах, ашиглах боломжийг бүрдүүлэх

Ангид байх ёстой:

- цензур
- арилжааны дарамт шахалт

Нийтийн номын сан нь:

- төрөөс санхүүждэг
- сайн байршил, тоног төхөөрөмжтэй
- мэргэжлийн хүний нөөц, материаллаг зүйлсээр хангагдсан
- мэргэжлийн хүнээр удирдуулдаг
- холбогдох хууль тогтоомж урт хугацааны стратегид тусгагдсан байх ёстой

Нийтийн номын сан болон номын сангийн үндэсний сүлжээг хөгжүүлэхийг дэмжицгээе!



mongolmedleg.org